

## Дүүргийн 34 хувийн гар утас ашиглахад олгох зөвшөөрлийн маягт

Боловсролын зөвлөл нь өөрийн сургуулийн сурагчдын аюулгүй байдал, сурч боловсрох таатай орчинг бүрдүүлэхэд сурагчдын гар утас, зүүдэг төхөөрөмж гэх мэт хувийн техник хэрэгслийг сурагчдын аюулгүй байдал, боловсрол олгох орчинг бүрдүүлэхэд сөрөгөөр нөлөөлөхгүй байдлаар олгоход оршино. Тиймээс дүүргийн бүх анги танхимд багш нарын зөвшөөрлөөр сурагчид ашиглах боломжтой утас байдаг.

### Цахилгаан дохиоллын төхөөрөмж

Сурагчид ямар ч үед сургууль дотор пейзаж цахилгаан дохиоллын төхөөрөмж, хоорондын радио, техник хэрэгсэл ашиглах, эзэмшихийг зөвшөөрөхгүй.

### Гар утас / Зүүдэг төхөөрөмж

Гар утас / зүүдэг төхөөрөмж эзэмших, ашиглахыг (ухаалаг цаг, хөдөлгөөний үйл ажиллагаа хянагч, хэмжигч гэх мэтээр хязгаарлагдахгүй) онцгой нөхцөл болон мөн ая тухтай байхын аль ч үед ашиглахгүй. Иймээс дараахь дүрмийг баримтална.

1. Эцэг эх нь хүүхдийнхээ гар утас/зүүдэг төхөөрөмжийг "Хувийн гар утас ашиглах зөвшөөрөл" -ийн маягтыг бөглөж гарын үсэг зурж сургуульд бүртгүүлсэн байх ёстой. Сурагчийн утсыг бүртгүүлээгүй тохиолдолд тухайн сурагчид сахилгын шийтгэл ногдуулж болзошгүй.
2. Энэхүү маягтыг тухайн хичээлийн жилийн турш сургуулийн файл дээр хадгална. Сургуулийн жил бүрийн эхэнд үүнийг шинэчлэх шаардлагатай.
3. Гар утас эсвэл зүүдэг төхөөрөмжийг хичээлийн цагаар ашиглахгүй бөгөөд энэ дүрмээс өөрөөр заагаагүй бол сургууль эхэлсэн цагаас эцсийн хонх дугарах хүртэл сурагчдын шүүгээнд хадгалагдах ёстой. Энэ хугацаанд гар утсыг унтраасан байх ёстой (дуут ая эсвэл чичиргээ дээр тахижгүй байх). Энэ дүрмийн цорын ганц үл хамаарах тохиолдол бол гар утсыг тогтоосон журмын дагуу зөвхөн багшийн зөвшөөрлөөр ашиглах тохиолдолд хэрэглэж болно. Сурагчийн тухайн өдөр нь сургуулийн хаалгаар орж ирсэн тэр цаг хугацаанд эхэлдэг гэдгийг сайн санах нь чухал. Гар утасны камер, текст мессеж, бусад нэмэлт төхөөрөмжүүдийг хичээлийн цагаар ашиглахгүй. Гэсэн хэдий ч, сурагчид хичээлийн өмнө болон дараа хянагч багшийн зөвшөөрөлтэйгээр, гар утас ашиглах маягтад гарын үсэг зурсан тохиолдолд гар утас, цахим төхөөрөмжөө ашиглаж болно.
4. Зүүдэг төхөөрөмжийг хичээлийн цагаар зүүж болох боловч харилцаа холбооны хэрэгсэл болон суралцах үйл ажиллагааны явцад багшийн зөвшөөрөл аваагүй тохиолдолд (тооны машин, тэмдэглэл хөтлөх апп зэрэг гэх мэт) ашиглахгүй. Хэрэв хичээлийн цагаар зүүж байгаа тохиолдолд харилцааны үйлдлийг (яриа, текст, мессеж гэх мэт) идэвхгүй болгосон байна. Энэ дүрмийн цорын ганц үл хамаарах тохиолдол бол гар утасны төхөөрөмжийг тогтоосон журмын дагуу зөвхөн багшийн зөвшөөрлөөр ашиглаж байгаа тохиолдолд хэрэглэж болно. Хэрэв ямар нэг асуудал болон зөрчил гарсан тохиолдолд багш техник хэрэгслийг ангийн тодорхой газар түр

- хадгалахыг хүсч болно.
5. Гар утасыг видео бичлэг хийх, хувийн дижитал туслах (PDA) болон бусад зүүдэг цахим хэрэгслийг боловсролын орчинд хөндлөнгөөс нөлөөлөх, бусдын эрхийг зөрчих ямар нэгэн хэлбэрээр ашиглах, тухайлбал төхөөрөмжийг хувцас солих өрөө, угаалгын өрөөнд зураг авахад ашиглах, хуулах, хуурах, сурагчийн ёс зүйн бусад журмыг зөрчихийг хориглоно.
  6. Энэхүү удирдамжийг зөрчсөн нь өмнө нь багшийн суралцах зориулалтаар ашиглахыг зөвшөөрөөгүй, сургуульд бүртгүүлээгүй iPod, iPad, Kindles, ухаалаг цаг гэх мэт бусад электрон төхөөрөмжүүдэд дээр дурдсантай ижил үр дагаварт хүргэнэ.
  7. Сурагчид гар утасныхаа аюулгүй байдлыг өөрсдөө хариуцна. Сургууль нь хувийн гар утас эсвэл зүүдэг төхөөрөмжид ямар ч хариуцлага хүлээхгүй бөгөөд хүүхдээ гар утсаар хангах шийдвэр нь эцэг эхийн шийдвэр болохыг анхаарна уу. Хулгайлагдсан болон алдагдсан тохиолдолд сургуулийн алдагдсан болон хулгайлагдсан эд зүйлсийн ердийн дүрэм журмын дагуу шийдвэрлэнэ. Эцэг эх шийдвэр гаргахдаа утас эсвэл зүүдэг төхөөрөмжийн төлбөр, алдагдсан, хулгайлагдсан тохиолдолд өөрсдөө хариуцлагыг хүлээнэ гэдгийг хүлээн зөвшөөрөх. Сургуулийн дүүрэг нь сургуульд авчирсан аливаа цахилгаан төхөөрөмжийн алдагдал, хулгайд хариуцлага хүлээхгүй.

Доор дурдсан удирдамжыг зөрчсөн тохиолдолд дараах үр дагаварт хүргэж болзошгүйг анхаарна уу. Та болон таны хүүхэд гар утастай холбоотой дүрэм, түүнчлэн гарч болох үр дагаврыг ойлгох нь чухал юм. Хэрэв танд энэ талаар ямар нэгэн асуулт байвал, сургуулийн захиралтай холбоо барина уу.

### Үр дагавар

Эхний зөрчил: Анхааруулга өгнө, сурагч утас эсвэл зүүдэг төхөөрөмжийг шүүгээнд эсвэл аюулгүй газар байрлуулж, уг хэрэгт тэмдэглэл хөтлөж бүртгэнэ.

Хоёрдахь зөрчил: Тухайн хичээлийн өдрийг дуустал хурааж авна, сурагч сахилга батын арга хэмжээ болон нас биед тохирсон хүмүүжлийн шийтгэл авна.

Гурав дахь зөрчил: Тухайн хичээлийн өдрийг дуустал хурааж, эцэг эх/асран хамгаалагч нь утсыг ирж авах ёстой бөгөөд сурагч сахилга батын арга хэмжээ болон нас биед тохирсон хүмүүжлийн ншийтгэлийг авна.

Дөрөвдүгээр зөрчил: Утас болон зүүдэг төхөөрөмжийг өдөр бүр оффис дээр ирж шалгуулаад үлдээх эсвэл жилийн турш гэртээ үлдээх ёстой.

Хэрэв та хүүхдээ гар утас эсвэл зүүдэг төхөөрөмж өгөхөөр шийдсэн бол 34-р дүүргийн гар утас ашиглах зөвшөөрлийн маягтыг бөглөж, сургуульд нь буцааж өгөх ёстой. Гэрээний маягтыг бөглөснөөр та сургууль дээр гар утас ашиглахтай холбоотой дээр дурдсан удирдамжыг уншиж, ойлгосон гэдгээ нотлож байгаа юм.

# Дүүргийн 34 хувийн гар утас ашиглахад олгох зөвшөөрлийн маягт

Энэхүү маягтын бүх хэсгийг бөглөсөн байна

Сурагчын нэр \_\_\_\_\_ Баг \_\_\_\_\_

Гэрийн утас \_\_\_\_\_

Эцэг эх/Асран хамгаалагч \_\_\_\_\_ өдрийн цагаар холбоо барих утас \_\_\_\_\_

Эцэг эх/Асран хамгаалагч \_\_\_\_\_ өдрийн цагаар холбоо барих утас \_\_\_\_\_

Гар утас болон зүүдэг төхөөрөмжийн загвар \_\_\_\_\_

Гар утас болон зүүдэг төхөөрөмжийн сериал дугаар (ихэвчлэн гар утасны цэнэглэгчийн доор байрладаг) \_\_\_\_\_

Гар утас болон зүүдэг төхөөрөмжийн дугаар \_\_\_\_\_

**Доор гарын үсэг зурснаар та Гар утас эсвэл зүүдэг төхөөрөмж ашиглахтай холбоотой сургуулийн дүүргийн удирдамжийг уншсан бөгөөд энэхүү бодлогын нөхцөлийг дагаж мөрдөхийг зөвшөөрч байгаа болно.**

\_\_\_\_\_  
Сурагчын гарын үсэг

\_\_\_\_\_  
Огноо

\_\_\_\_\_  
Эцэг эхийн гарын үсэг

\_\_\_\_\_  
Огноо

\_\_\_\_\_  
Асран хамгаалагчийн гарын үсэг

\_\_\_\_\_  
Огноо